


Living the LOTUS

Buddhism in Everyday Life



1
2019

VOL. 160

Үүсгэн байгуулагчийн сургаал

Дадал зуршлын хүч

Жүдогийн мэх ч тэр, бейсбол болон гольфийн цохиураар бөмбөг цохих техник ч тэр “ингэж хийдэг” гэж ганц заалгуулаад шууд сурчих зүйл биш. Өдөр бүр давтаж, бэлтгэл сургуулилт хийсний үр дүнд дадал болдог ба тэмцээн дээр тэрхүү үр дүн нь харагддаг.

Шашин шүтлэг ч гэсэн адилхан. Толгойгоороо ойлгоход амархан ч өөрийн болгож, эзэмшихийн тулд өдөр бүрийн үйлийг орхигдуулж болохгүй. Ялангуяа хүмүүс өөрөө л хийнэ гээд шийдчихвэл болоо, тийм сэтгэл л байвал болчих юм шиг эндүүрч бодох нь элбэг байдаг. Гэвч дадал, зуршлын хүчийг мартаж болохгүй.

Сайн зуршил ч тэр, муу зуршил ч тэр дадал болчихвол хүний бодол санаа, шийдвэрт нөлөөлөөд зогсохгүй амьдралд нь нөлөөлж орхино. Сайн зуршлыг дадал болговол хичээгээгүй байсан ч үйлс нь цаанаасаа л бүтээд байдаг. Харин муу хэвшлийн дадал болгочихвол өөрийн бодолдоо ч захирагдахгүй муу зүг лүү явж орхидог.

Уулзах хүн, учрах нөхцөл байдлыг хүлээж авах байдал, бодох арга, үйлдэлээ бурханы сургаалаас гажихгүй байх дадлыг бий болгох нь маш чухал. Сайн дадлыг бий болгох бэлтгэл хийх газар нь номын андуудынхаа дунд буюу та бидний салбар, сүм юм.

Үүсгэн байгуулагчийн сургаал 9, 30-31х

Living the Lotus Vol. 160 (2019.01)

Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс

Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537 Japan

TEL: +81-3-5341-1124

FAX: +81-3-5341-1224

Email: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Ахлах редактор: Саитоо Коочироо

Орчуулсан: Б.Мөнхцэцэг, Ж.Гэрэлтуяа

Эхийг хянасан: Монголын РКК

Рисшо Косей кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо болон түүний шавь Хамтран үндэслэгч Наганүма Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Гурван Эрдэнийн Цагаан Лянхуа Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулья гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Гишүүд бид бурхан багшийн шавь болохынхоо хувьд тус байгууллагын Ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн, энх тайвны олон янзын үйл ажиллагаа явуулж байна.

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд, Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнэтэй амьдралыг туулцаага гэсэн хүсэл шингэсэн билээ. Бид энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.

Бүх хүний дотор сайны үндэс байдаг

Рисшо Косей Кай, Ерөнхийлөгч
Нивано Ничикоо



Хатсан үндсэнд чийг өгөх нь

Шинэ оны мэнд хүргэе. Энэ жил ч гэсэн хамтдаа баяр хөөртэйгөөр, хувирашгүй сэтгэлээр бурханы зам мөрөөр явцгаая.

Та бүгд тус бүрийнхээ тангарагийг тээн, олон хүнд бурханы сургаалыг түгээнэ хэмээн бодож байгаа байх.

Нөгөөтэйгүүр янз бүрийн шалтгааны улмаас дотор нь онгойхгүй, “асуудлыг өөдрөгөөр харж чадахгүй” байна гэх хүн ч байж магадгүй.

Залуудаа хүнд өвчинд нэрвэгдэж, насан туршдаа өвчин нь эдгэхгүй гэсэн онош эмчээс сонссон нэгэн хүний яриаг та бүхэнтэй хуваалцъя. Ирээдүй нь бүрхэг санагдаж, амьдрах итгэлээ алдах шахаад байх үед шашин шүтлэгийн хувьд өөрөөс нь туршлагатай анд нь тэр хүнд байнга “чиний дотор сайны үндэс байгаа” гэсэн үгийг хэлдэг байж.

Тэр үгийг сонссоор байгаад, нэг мэдэхэд өөрийгөө үгүйсгэх, амьдралыг гутрангүй харах байдал нь арилж, “бусдын төлөө ямар нэг зүйл хийхсэн” гэсэн эрмэлзэл оргилон гарч ирсэн гэнэ.

Бидний уншиж шүтдэг Лянхуан гурамсан судар (орч.Болдбаатар.Т УБ., (2012), “Адмон принт” хэвлэл, 17 тал)-ын Хэмжээлшгүй Утгасын Судар “Буяны явдлыг үгүүлэх бүлэг”-т “*хамаг амьтны буяны үндсийг чийглэн услаад*” гэсэн хэсэг гардаг.

Буяны үндэс гэдэг сайн үр нөлөөг үзүүлэх үндсийг хэлж байгаа юм. Сайн үндэс гэдгийг миний хувьд “хүн бүрт бурхан буддатай ижилхэн мөн чанар байгаа бөгөөд бүх хүн бурханы илрэл” гэдгийг илэрхийлдэг “бурханлаг чанар”-тай ижилхэн утгатай гэж ойлгодог. Тиймээс бүх хүн сайны үндсийг тээдэг гэж хэлж болно. Гэвч тэр үндсийг эрүүл өсгөж, ургуулахын тулд хатсан үндсийг сэргээх чийгийг өгөх шаардлагатай.

Амьдрах хүслээ алдаж, өөрийгөө голсон залуугийн хувьд “бусадтай зүйрлүүлэшгүй сайны үндэс таны дотор байна” гэсэн үг өөрийнх нь үнэ цэнийг мэдрүүлээд зогсохгүй, хуурайшч, хатсан үндсэнд харамгүйгээр ус, чийгийг өгөж байгаагаас ялгаагүй байсан бизээ.

Одоо тэр хүн өөрийнх нь залуу байх үеийнхтэй ижил зовж шаналсан хүмүүстэй харилцаж, сайны үндсийг нь чийглэн, бурханы сургаалыг түгээх үүрэг хүлээн ажиллаж байгаа.





Жинхэнэ “зөв бясалгалын андууд”

Хэмжээлшгүй Утгасын Судар “Буяны явдлыг үгүүлэх бүлэг”-т “буяны үндсийг чийглэн услаад” гэдгийн хойноос “буяны үрийг сацааж, эрдмийн тариаланг дүүргээд” гэсэн хэсэг үргэлжилдэг. “Хорвоо ертөнцийн сайн сайхны төлөө, хүмүүсийн төлөө зүтгэх сайн үйлийн үрийг олноор нь суулгацгаая” –өөрөөр хэлбэл “бурханы сургаалыг дамжуулж, өөрөө ч тэр, хүмүүс ч тэр хамтдаа аз жаргалд хүрцгээе” гэсэн “сургаалыг түгээх” талаар айлдсан байна.

“Буяны үрийг сацааж” гэдэг нь хүмүүсийн хатсан үндсэнд нь ус чийг өгөх гэдэгтэй утгын хувьд ижил юм. Гэвч энд яагаад гэнэт “сургаал түгээх” талаар дурьдсан байна вэ, шалтгаан нь ердөө л ганцхан. Өмнө нь дурьдсан залуутай ижил бурханы сургаалыг сонсоод сэтгэл дэх үндэс нь чийгшиж, төөрөгдлийн хавцлаас гарсны дараа “өөртэй нь ижил асуудлаас болоод зовж байгаа хүмүүст тусалж, эргэн тойрондоо байгаа аз жаргалыг анзаараасай” хэмээх нигүүлсэнгүй сэтгэл оргилон гарч ирдэг учраас юм.

Тэгвэл энэхүү “сургаал түгээлт” ямар байх ёстой вэ? Шаналж байгаа залуус анхнаасаа л бурханы сургаалыг шууд дуулгавартай хүлээн аваагүй. Тэр утгаараа бидний хувьд “эхлээд эргэн тойрны хүмүүстэй сайхан хандая, сайн учрал нь больё” хэмээн хүсэх чухал. Учир нь хүнийг бодсон эелдэг үг, үйлдэл зовж шаналж байгаа хүмүүсийн сэтгэл дэх хатсан үндсэнд ус чийг болж очдог болохоор юм.

Дээрээс нь нэмээд номын уншлага болон бурханы сургаалаас суралцах зэргийн үндсэн үйлүүдийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ, бурханы сургаалыг мэдэхгүй хүмүүст дамжуулах.

Ийм амьдралын хэв маяг нь дээр дурьдсан судрын хэсгийн гол зангилаа болох “хотлоор хамаг амьтнаа бодийн нахиаг ургуулмуу” (янз бүрийн хүмүүст бурханы гэгээрлийг зорих бодь сэтгэлийн бий болгох) гэсэн хамгийн эрхэм дээд амьдралтай холбох болно.

Ийнхүү бүгдээрээ “бурхан будда шиг болмоор байна” гэж бат шийдсэн нөхөд бол- жинхэнэ утгаараа “зөв бясалгалын андууд” юм.

Миний сурч байсан их сургуулийн хүндэлж явдаг багш маань “сургаал түгээлт байхгүйгээр шашин ч оршин тогтнохгүй” гэж хэлж билээ. Бид хэзээд авралыг хүсэх хүмүүсийн сэтгэлийг нь амгаланд хүргэх “зөв бясалгалын андууд” нь байхсан гэж бодогдоно.

“Косей” сэтгүүл 1-р сарын дугаараас



Лянхуан Гурамсан Сударын бүлэг тус бүрийн тайлбар

Оройн Дээд Цагаан Лянхуа Судар Сүслэн авахуйг үгүүлэх 4-р бүлэг

Итгэх ба ойлгох

Энэ бүлгийн сэдэв болох “итгэх ба ойлгох”-ын “ойлгох” гэдэг нь асуудлыг логик ухамсраар харж “үүнийг л хэлээд байж” хэмээн толгойгоороо тодорхой ойлгохыг хэлж байгаа бөгөөд “итгэх” гэдэг нь тэрхүү ойлгосон зүйлээ сэтгэлдээ хүлээн авч, огтхон ч эргэлзээ тээхгүй байхыг хэлнэ.

Бодот байдал дээр шинжлэх ухаан, технологиос авахуулаад амьдралд хэрэгтэй мэдлэгүүдийг эхлээд ойлгоод, түүнийгээ зөвөөр “онолын дагуу” хэрэгжүүлээд явахад л болно гэсэн ерөнхий ойлголт байдаг. Гэвч хорвоо ертөнцийн гольдрол шулуун дардан байхын тулд энэ хангалтгүй. Үүний тулд “итгэл” гэдэг ухагдахуун байхгүй бол болохгүй.

Бидний өдөр тутамдаа хэрэглэдэг үржихийн хүрдээр жишээ авъя. “8-н 9-ийн 72” гэхэд бид яагаад 72 юм бол гэж дотроо нэг бүрчлэн тоо бодоод байдаггүй. Учир нь бага ангид байхдаа 9-ийн хүрд гэж заалгуулж, түүнийгээ үнэн гэж бат итгэсэн байдаг тул ямар ч эргэлзээгүйгээр “7-н 9-ийн 63”, “8-н 9-ийн 72” гэх зэргээр цээжээрээ тоо боддог. Үнэн, бодот бол ингэх нь зөв. Ийм ч байхгүй бол болохгүй байх.

Энэхүү “итгэх” гэдэг шашины сургаалын хувьд бүр ч орхигдуулж болохгүй ойлголт юм. Буддын шашин нь орчин цагийн шинжлэх ухаантай нийцэх, логик сэтгэлгээгээр ч ойлгох сургаал номлолтой тул эхлээд “ойлгох” нь чухал байдаг ч энэ нь дангаараа хангалтгүй. Тэрхүү ойлголт нь гүнзгийрснээр хүчтэй сэтгэл хөдлөл үүсч, улмаар баяр хөөр оргилон гарч, сэтгэлийн гүнээс тэр сургаалыг дагая хэмээх итгэл төрж байж, “жинхэнэ аврал” биелэлээ олно. Сэтгэлийн яг ийм хэв шинжийг сүсэглэх гэж хэлэх ба сүсэг бишрэл гэж үүнийг л хэлээд байгаа юм. Хэдийгээр буддын шашины сургаал номлолыг шинжлэх ухаанлаг гэгцгээдэг ч сургаалыг ойлгохоос гадна итгэн сүсэглэж, дагах түвшин хүртэл явахгүй бол үнэ цэнэ нь гарч ирэхгүй.

Ингээд гол сэдэв лүүгээ орцгооё. “Үлгэр

зүйрлэлийг үгүүлэх 3-р бүлэг”-ийн айлдварыг сонсоод Шаарийбуугаас эхлээд сүсэглэн ойлгохын төгс түвшинд хүрсэн шавь нар хэд хэд гарч ирэв. Тэд бол Субуди, Маха-Катяяна, Маха-Каашяпа, Маха-Маудгалаяна хэмээх дөрвөн ширваган хувраг юм. Юуг төгс ойлгосон бэ гэхээр “уран арга бүлэг”-т Бурхан багш айлдвараараа далдуур илэрхийлсэн “хүн бүрт бурханлаг чанар оршдог бөгөөд хэн ч гэгээрэлд хүрч чадна”, мөн “Бурхан янз бүрийн уран аргыг хэрэглэн сургаалаа айлддаг боловч эцсийн зорилго нь хүн бүр өөрийнхөө дотор орших бурханлаг чанараа олж илрүүлэн, гэгээрэл гэж ямар түвшин болохыг ойлгох гэсэн ганц зүйлийн төлөө” гэдгийг ойлгосон юм.

Дөрвөн хувраг зөвхөн дотроо ойлгоод зогсохгүй, “бид ингэж ойлголоо” хэмээн Шагжамүни буддагийн өмнө дэлгэрэнгүй гарган хэлдэг. Энэ их чухал бөгөөд өөрийн сүсэг бишрэлийн туршлагаа хүмүүсийн өмнө ярьснаар сүсгийн сэтгэл улам батжиж, хөдлөшгүй болдог учраас юм.

Энэ дөрвөн хуврагийг төлөөлөн Маха-Каашяпа Шагжамүни буддад хандан өөрийн туршлагыг ярьдаг ба маш уран яруу үлгэрлэл хэлбэртэй байх бөгөөд нэрийг нь “баян ноён ба ядуу хүүгийн үлгэр” хэмээнэ. Энэхүү үлгэр бол Цагаан Лянхуа судрын нэгэн чимэг болсон хэсэг юм. Агуулгыг доор дурьдсан тул хүлээн авна уу.





Баян ноён ба ядуу хүүгийн үлгэр

“Бага залуу байхдаа эцгийнхээ гэрээс дайжиж, тэнүүчлэн амьдардаг нэгэн эр байжээ. Тавин нас хүртлээ харийн орнуудаар хэрэн хэсэж, ядуу тарчиг амьдралаар амьдардаг байлаа. Гэтэл нас хэлбийх үед өөрийн мэдэлгүй эцгийнхээ гэр рүү зүглэх болов.

Харин Эцэг нь ганц хүүгээ гэрээсээ явахад нь ихэд гуниглан, хаа сайгүй хайсан боловч олдсонгүй. Ингээд эрэл мухардсан тул аргагүйн эрхэнд нэгэн хотод амьдрах болжээ. Эцэг нь асар их хөрөнгийг эзэмшиж, хээнцэр орд харшид амьдардаг байлаа.

Хүү нь хэрэн тэнүүлчилж яваад санаандгүй тэр хотод ирэх ба эцгийнхээ амьдардаг ордны өмнүүр өнгөрөн гардаг байна. Тэгэхдээ ямар нэг хийх ажил байхгүй байгаа хэмээн ордны дотогш өнгийн харвал улсын хаан лугаа ноёнтон олон барлагуудаар хүрээлүүлэн суух агаад түүний төрх байдал нь туйлын сүрлэг ажээ.

Тэр эрэгтэйд сүрдэх сэтгэл төрж, дэмий сэлгүүцэж байгаад баригдвал хүчээр ажил хийлгэж мэднэ, надад тохирох газар биш байна хэмээн бодоод, алхаагаа түргэсгэн бушуухан холдохын түүс болов.

Харин баян эцэг нь нэг хором ч хүүгээ мартаж байгаагүй тул хаалганы өмнө зогсох ноорхой эрийг хараад төрсөн хүүгээ мөн байна хэмээн шууд танина. Даруй барлагууддаа ядуу эрийг дагуулан ирэхийг тушаана. Гэтэл эцгийн сэтгэлийг мэдэхгүй хүү (ядуу хүү) нь алуулах нь хэмээн айгаад, барлагуудын гараас мултрах гэж чаргууцалдаж байгаад ухаан алдаж орхидог байна. Үүнийг харсан эцэг нь хүчээр авчруулахаа болиулна. Тэгээд хэсэг хугацаа өнгөрсний дараагаар ядуу эрийн байгаа газар луу үзэмжгүй бохир хувцасласан хоёр барлагаа явуулж, “бохир зүйл цэвэрлэдэг ажил байна, хөлс нь энгийн ажлаас 2 дахин ихийг авдаг гэнэ, цуг хийх үү” хэмээн хэлүүлж, ордны дотор оруулж дөнгөдөг байна. Баян ноёнтон өөрөө ч бохир хувцас өмсөн, ядуу хүний дүрд хувилгаад хүүгийнхээ эмээх сэтгэлийг бага багаар



арилган, эелдэг зөөлөн, урмын үг хэлсээр ядуу эртэй дотносон, өөрийн өргөмөл хүүгээ болгох хэмжээнд хүрнэ.

Ядуу эр, настай эр өөрт нь сайн хандахад баярлах боловч над мэтэд тохирохгүй гэсэн өөрийгөө голж, чамлах сэтгэл нь огтоос алга болохгүй байлаа. Эцэг нь хүүдээ янз бүрийн ажил даалгаж хийлгэсээр эцэстээ бүх хөрөнгийг хариуцах байр сууринд томилно. Ядуу хүү шударга хичээнгүйгээр ажиллаж, өөрийн үүргээ гайхалтай сайн биелүүлэх боловч “над шиг дорд хүнд ийм ажил даалгах гэж” гэсэн өөрийгөө голох сэтгэл нь арилахгүй л байлаа. Цаг хугацаа өнгөрөхийн хирээр, ядуу хүүгийн өөрийгөө голох сэтгэл аажим аажмаар багасч ирэв.

Эцэг нь өөрийн насны төгсгөл ойртож ирснийг мэдээд улсын хаан, эрх мэдэл бүхий ноёдуудыг цуглуулан “энэ эр бол миний төрсөн хүү бөгөөд миний бүх хөрөнгө энэ хүүхдийнх юм” хэмээн тэдний өмнө зарлан тунхагладаг байна.

Ядуу хүү тэр үед анх удаа баян ноён өөрийнх нь төрсөн эцэг байсныг, мөн эцгийнх нь хязгааргүй хөрөнгө бүгд өөрийнх нь байсныг мэдээд хязгааргүй их баяр хөөрт автана.”

Нивано Никкёо “Лянхуан Гурамсан Сударын бүлэг тус бүрийн тайлбар /шинэ хэвлэл/”, Косей хэвлэлийн компани, 2016, X 57-63

Жинхэнэ зөв бясалгалын андууд

Он солигдож, шинэ он гарлаа. Миний хувьд олон улсын хэлтэст томилогдож ирснээс хойш угтаж буй 2 дахь жил. Энэ жил ч гэсэн “талархал ба бодисадвагийн үйл” гэсэн зоригтыг өөртөө тавьж, хичээх болно.


Ерөнхийлөгч Косей сэтгүүлийн 1-р сарын дугаарт дахин “сургаал түгээлт” ямар чухал вэ гэдэг талаар айлдсан байна. Хүмүүст өөрийнх нь үнэ цэнийг анзааруулахын тулд хүний төлөө гэсэн сэтгэлээс уялдаатай эелдэг зөөлөн үг, үйлдэлээр дамжуулж нөгөө хүндээ сайн учрал болох-зовж шаналж байгаа хүмүүсийн сэтгэлийг тайтгаруулах хүн болох нь ямар чухал вэ гэдгийг бидэнд заасан байна.

Энэ жил АНУ-д сургаал түгээсний 60 жилийн ой тохиож байгаагийн зэрэгцээ олон улсад сургаал түгээсний 60 жилийн ой ч давхцаж байгаа билээ. “Цагаан лянхуан сургаалаар дамжуулж, дэлхий дахины хүмүүс аврагдаасай” хэмээх үүрэг даалгаварыг дэлхийн өнцөг булан бүрт байгаа номын андууддаа дамжуулж, жинхэнэ “зөв бясалгалын андууд” болохыг зорин сургаал түгээх үйлийн төлөө зүтгэе гэж бодно. Энэ жил ч гэсэн та бүхний тус дэмийг хүртэх тул туслаж дэмжихийг хүсье.

РКК, Олон улсын хэлтсийн дарга
Саитоо Коичи



Rissho Kosei-kai: A Global Buddhist Movement



Rissho Kosei-kai International

Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
 Tel: 81-3-5341-1124 Fax: 81-3-5341-1224
 e-mail: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Rissho Kosei-kai International of North America (RKINA)

2707 East First Street, Suite #1, Los Angeles, CA 90033, U.S.A.
 Tel: 1-323-262-4430 Fax: 1-323-262-4437
 e-mail: info@rkina.org <http://www.rkina.org>

Branch under RKINA

Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003 U.S.A.
 Tel: 1-253-945-0024 Fax: 1-253-945-0261
 e-mail: rkseattlewashington@gmail.com
<http://buddhistlearningcenter.org/>

Rissho Kosei-kai Buddhist Center of San Antonio

6083 Babcock Road, San Antonio, TX 78240, U.S.A.
 P.O. Box 692148, San Antonio, TX 78269, U.S.A.
 Tel: 1-210-561-7991 Fax: 1-210-696-7745
 e-mail: dharmasanantonio@gmail.com
<http://www.rkina.org/sanantonio.html>

Rissho Kosei-kai of Tampa Bay

2470 Nursery Road, Clearwater, FL 33764, U.S.A.
 Tel: (727) 560-2927 e-mail: rktampabay@yahoo.com
<http://www.buddhismtampabay.org/>

Rissho Kosei-kai of Vancouver

Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, U.S.A.
 Tel: 1-808-455-3212 Fax: 1-808-455-4633
 e-mail: info@rkhawaii.org <http://www.rkhawaii.org>

Rissho Kosei-kai Maui Dharma Center

1817 Nani Street, Wailuku, HI 96793, U.S.A.
 Tel: 1-808-242-6175 Fax: 1-808-244-4625

Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona, HI 96740 U.S.A.
 Tel: 1-808-325-0015 Fax: 1-808-333-5537

Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, U.S.A.
 Tel: 1-323-269-4741 Fax: 1-323-269-4567
 e-mail: rk-la@sbcglobal.net <http://www.rkina.org/losangeles.html>

Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona

Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado
 Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego
 Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas
 Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas

Rissho Kosei-kai of San Francisco

1031 Valencia Way, Pacifica, CA 94044, U.S.A.
 Tel: 1-650-359-6951 Fax: 1-650-359-6437
 e-mail: info@rksf.org <http://www.rksf.org>

Rissho Kosei-kai of Sacramento

Rissho Kosei-kai of San Jose

Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016 U.S.A.
 Tel: 1-212-867-5677 Fax: 1-212-697-6499
 e-mail: rkny39@gmail.com <http://rk-ny.org/>

Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056 U.S.A.
 Tel: 1-773-842-5654 e-mail: murakami4838@aol.com
<http://rkchi.org/>

Rissho Kosei-kai of Fort Myers

<http://www.rkftmyersbuddhism.org/>

Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

2745 N.W. 40th Street, Oklahoma City, OK 73112 U.S.A.
 Tel: 1-405-943-5030 Fax: 1-405-943-5303
 e-mail: rkokdc@gmail.com <http://www.rkok-dharmacenter.org>

Rissho Kosei-kai Dharma Center of Denver

1255 Galapago Street, #809 Denver, CO 80204 U.S.A.
 Tel: 1-303-446-0792

Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

425 Patterson Road, Dayton, OH 45419 U.S.A.
<http://www.rkina-dayton.com/>

Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP,
 CEP 04116-060 Brasil
 Tel: 55-11-5549-4446 / 55-11-5573-8377 Fax: 55-11-5549-4304
 e-mail: rissho@terra.com.br <http://www.rkk.org.br>

Rissho Kosei-kai de Mogi das Cruzes

Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP,
 CEP 08730-000 Brasil
 Tel: 55-11-5549-4446 / 55-11-5573-8377

Rissho Kosei-kai of Taipei

4F, No. 10 Hengyang Road, Zhongjheng District,
Taipei City 100, Taiwan
Tel: 886-2-2381-1632 Fax: 886-2-2331-3433
<http://kosei-kai.blogspot.com/>

Rissho Kosei-kai of Tainan

No. 45, Chongming 23rd Street, East District,
Tainan City 701, Taiwan
Tel: 886-6-289-1478 Fax: 886-6-289-1488

Korean Rissho Kosei-kai

6-3, 8 gil Hannamdaero Yongsan gu, Seoul, 04420,
Republic of Korea
Tel: 82-2-796-5571 Fax: 82-2-796-1696
e-mail: krkk1125@hotmail.com

Korean Rissho Kosei-kai of Busan

3F, 174 Suyoung ro, Nam gu, Busan, 48460, Republic of Korea
Tel: 82-51-643-5571 Fax: 82-51-643-5572

International Buddhist Congregation (IBC)

Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
Tel: 81-3-5341-1230 Fax: 81-3-5341-1224
e-mail: ibcrk@kosei-kai.or.jp <http://www.ibc-rk.org/>

Branches under the Headquarters**Rissho Kosei-kai of Hong Kong**

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road,
North Point, Hong Kong, Republic of China

Rissho Kosei-kai of Ulaanbaatar

15F Express tower, Peace avenue, khoroo-1, Chingeltei district,
Ulaanbaatar 15160, Mongolia
Tel: 976-70006960 e-mail: rkkmongolia@yahoo.co.jp

Rissho Kosei-kai of Sakhalin

4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk
693005, Russian Federation
Tel & Fax: 7-4242-77-05-14

Rissho Kosei-kai Friends in Shanghai**Rissho Kosei-kai of South Asia Division**

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 Fax: 66-2-716-8218

Rissho Kosei-kai International of South Asia (RKISA)

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 Fax: 66-2-716-8218
e-mail: thairissho@csloxinfo.com

Branches under the South Asia Division**Rissho Kosei-kai of Delhi**

77 Basement D.D.A. Site No. 1, New Rajinder Nagar,
New Delhi 110060, India

Rissho Kosei-kai of Kolkata

E-243 B. P. Township, P. O. Panchasayar, Kolkata 700094,
West Bengal, India

Rissho Kosei-kai of Kolkata North

AE/D/12 Arjunpur East, Teghoria, Kolkata 700059,
West Bengal, India

Rissho Kosei-kai of Bodhgaya

Ambedkar Nagar, West Police Line Road
Rumpur, Gaya-823001, Bihar, India

Rissho Kosei-kai of Kathmandu

Ward No. 3, Jhamsilhel, Sancepa-1, Lalitpur, Kathmandu,
Nepal

Rissho Kosei-kai of Phnom Penh

#201E2, St 128, Sangkat Mittapheap, Khan 7 Makara,
Phnom Penh, Cambodia

Rissho Kosei-kai of Patna**Rissho Kosei-kai of Singapore****Thai Rissho Friendship Foundation**

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 Fax: 66-2-716-8218
e-mail: info.thairissho@gmail.com

Rissho Kosei-kai of Bangladesh

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
Tel & Fax: 880-31-626575

Rissho Kosei-kai of Dhaka

House#408/8, Road#7(West), D.O.H.S Baridhara,
Dhaka Cant.-1206, Bangladesh
Tel & Fax: 880-2-8413855

Rissho Kosei-kai of Mayani

Mayani(Barua Para), Post Office: Abutorab, Police Station:
Mirshari, District: Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Patiya

Patiya, sadar, Patiya, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Domdama

Domdama, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Cox's Bazar

Ume Burmese Market, Main Road Teck Para, Cox'sbazar,
Bangladesh

Rissho Kosei-kai of Satbaria

Satbaria, Hajirpara, Chandanish, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Laksham

Dupchar (West Para), Bhora Jatgat pur, Laksham, Comilla,
Bangladesh

Rissho Kosei-kai of Raozan

West Raozan, Ramjan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Chendirpuni

Chendirpuni, Adhunagor, Lohagara, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Ramu**Rissho Kosei Dhamma Foundation, Sri Lanka**

No. 628-A, Station Road, Hunupitiya, Wattala, Sri Lanka
Tel: 94-11-2982406 Fax: 94-11-2982405

Rissho Kosei-kai of Habarana

151, Damulla Road, Habarana, Sri Lanka

Rissho Kosei-kai of Polonnaruwa**Branches under the Headquarters****Rissho Kosei-kai di Roma**

Via Torino, 29-00184 Roma, Italia
Tel & Fax: 39-06-48913949 e-mail: roma@rk-euro.org

Rissho Kosei-kai of the UK**Rissho Kosei-kai of Venezia****Rissho Kosei-kai of Paris**